

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТУХАЙ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

2015 оны 5 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Ганхуяг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо дээрх хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хийлээ.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар хийх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл хуулийн төсөл батлагдсанаар төсвийн дахин хуваарилалтаар орон нутагт эрх мэдэл олгож байгаа боловч тусгай зөвшөөрөл олноор гаргуулахын тулд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн бодлогоороо нэг талын хамааралтай эдийн засгийг дэмжсэн шийдвэр болж байгаа тул дэмжихгүй, Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан хуулийн төсөл нь байгалийн баялгаа хяналтгүйгээр ашиглах, төрийн албан хаагчид хөрөнгө оруулагчдын нөлөөнд автаж, ард иргэдийн шийдвэрээс гажих зэрэг сөрөг нөхцөлийг бүрдүүлэхээр байгааг анхаарах, харин стратегийн том орд газраа төрийн оролцоотой, эдийн засгийн үр өгөөжтэй ашиглан хөгжих хэрэгтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.


Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БОЛОР